

Хууль, эрх зүйн мэдээлэл #5

2026 оны 8-р сар

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛЬ БОЛОН ТҮҮНИЙ ОНЦЛОХ ЗОХИЦУУЛАЛТУУД

Хураангуй

Монгол Улсын Их Хурал 2026 оны 7 дугаар сарын 02-ны өдөр “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль”-ийг баталж, уг хууль нь 2026 оны 8 дугаар сарын 03-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэллээ. Энэхүү хууль нь Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, зохицуулалтыг анх удаа нэгдсэн эрх зүйн хүрээнд зохицуулсан бие даасан хууль болсон бөгөөд ийнхүү Монгол Улс олон улсын өмнө Парисын хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох үндэс суурь тавигдаж байна.

Тус хуулиар төрийн байгууллагуудын бүрэн эрх, үүрэг, тайлагналт, судалгаа шинжилгээ, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүнийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах шингээлтийг нэмэгдүүлэх бодлого, төлөвлөлтийн талаарх төрийн байгууллагын оролцоо, уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний платформ зэргийг зохицуулжээ. Үүнээс гадна тус хууль нь хувийн хэвшил, хөрөнгө оруулагч, төсөл хэрэгжүүлэгч нарт хамааралтай шинэ зохицуулалтууд болох ногоон болон уур амьсгалын санхүүжилт болон карбон зах зээлийн механизмыг агуулжээ.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нарийвчилсан харилцааг зохицуулсан журмууд тухайлбал ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн бүртгэл, карбон кредитийн бүртгэл, хүлэмжийн хийн хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт болон Үндэсний платформын үйл ажиллагаатай холбоотой журмуудыг хууль хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дотор эрх бүхий байгууллагууд батлах үүргийг хүлээсэн.

Бид энэхүү хууль, эрх зүйн мэдээллээрээ аж ахуйн нэгж, байгууллага, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч, хөрөнгө оруулагч болон тэдгээрийн бусад оролцогч талуудад ач холбогдолтой байж болох зохицуулалтуудыг онцлон хураангуйлан хүргэж байна.

Холбоо барих:

Abdulkhamid Muminov

Партнер

Татвар, Хуулийн үйлчилгээ

abdulkhamid.m.muminov@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал

Татвар, Хуулийн үйлчилгээ

tsendmaa.choijamts@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүперс

Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар

601 тоот, Улаанбаатар

14200, Монгол улс

Утас : + 976 70009089

www.pwc.com/mn

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Ахлах менежер

Татвар, Хуулийн үйлчилгээ

munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Рэнцэнтавхайн Мандухай

Ахлах хуульч

Татвар, Хуулийн үйлчилгээ

mandukhai.rentsantantavkhai@pwc.com

№ Онцлох зохицуулалтууд**i. Ногоон болон уур амьсгалын санхүүжилт**

Ногоон санхүүжилт нь өмнө нь Монгол Улсын Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөлийн ногоон таксономи болон санхүүгийн байгууллагын шаардлагын хүрээнд хэрэгжиж ирсэн бөгөөд тусгайлсан хуулийн зохицуулалтгүй байв.

Харин Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль батлагдсанаар ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн нэгдсэн эрх зүйн зохицуулалттай болов. Тухайлбал, уур амьсгалын санхүүжилт гэх шинэ ойлголт бий болсон бөгөөд энэ нь ногоон санхүүжилтийн нэг бүрэлдэхүүн хэсэг байхаар хуульд тусгажээ. Мөн төрийн байгууллагаас ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн эх үүсвэр, зориулалт, хэрэгжилт, үр дүнгийн мэдээллийг бүртгэж, түүнийг хянах, тайлагнах үүрэгтэй байхаар зохицуулсан байна.

Ногоон санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны шаардлага


Тус хуулиар ногоон санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, үйл ажиллагаанд тодорхой шаардлагуудыг тавьсан байгаагаас онцлон дурдвал ногоон санхүүжилтээр хэрэгжих төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа нь ногоон таксономи, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын шаардлагыг хангасан байхаас гадна үр дүн нь бодит, хэмжигдэхүйц, баталгаажихуйц байх ёстой.

ii. Карбон зах зээл болон карбон кредит

Тус хуулиар карбон зах зээл болон карбон кредит гэх шинэ ойлголтыг хуульчилжээ. Карбон зах зээл гэж карбон кредит болон олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглахтай холбоотой зах зээлийг ойлгоно.

Карбон зах зээлийн төрөл болон төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны үр дүн

Карбон зах зээлийг зохицуулалтын түвшин, хамрах хүрээ болон ашиглалтаас хамааран (i) олон талт, (ii) хоёр талт, (iii) үндэсний, (iv) дүйцүүлэх болон (v) сайн дурын гэсэн төрөлтэй байхаар ангилж, эдгээр зах зээлийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүнгүүд үүсгэхээр зохицуулжээ.



www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээлэлд үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.

Онцлох зохицуулалтууд (үргэлжлэл)

Карбон зах зээлийн хүрээнд хэрэгжих төслийн шаардлага болон төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг

Карбон зах зээлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тухайлбал орон нутгийн иргэдэд төсөл, хөтөлбөрийг танилцуулж, санал авах зэрэг хуульд заасан шаардлагуудыг хангасан байхаас гадна төсөл хэрэгжүүлэгч нь хуульд заасан үүргийг хүлээх бөгөөд тухайлбал:

1. Төсөл хөтөлбөрийг карбон кредитийн бүртгэлийн системд бүртгүүлж, хуульд заасан тодорхойлолтуудыг авна.
2. Баталгаажсан карбон кредитийг карбон кредитийн бүртгэлийн системд бүртгүүлнэ. Ингэснээр карбон кредитийг эзэмших, ашиглах, шилжүүлэх, худалдах, арилжих, захиран зарцуулах эрх үүснэ.
3. Сааруулалтын үр дүн үүсгэх төсөл, хөтөлбөрийн хүлэмжийн хийн ялгарлын хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтыг баталсан аргачлалын дагуу жил бүр холбогдох олон улсын болон үндэсний стандартын дагуу итгэмжлэгдсэн, хараат бус этгээдээр гүйцэтгүүлж, Үндэсний зохицуулагч байгууллагад хүргүүлнэ.
4. Сайн дурын карбон зах зээлийн хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрөөс үүсэх карбон кредиттэй холбоотой хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тайланг баталгаажуулалт хийгдсэний дараа Үндэсний зохицуулагч байгууллагад хүргүүлнэ.

Карбон кредитийн эзэмшил болон ашгийн хуваарилалт

Улсын болон орон нутгийн төсвөөс бусад эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төслийн карбон кредитийг төсөл хэрэгжүүлэгч нь эзэмшихгүй байж болно. Өөрөөр хэлбэл улсын болон орон нутгийн төсвөөс бусад эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төслийн карбон кредитийг эзэмших этгээдийг гэрээгээр тогтоохоор хуульчилсан. Харин олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг төсөл хэрэгжүүлэгч талуудын хооронд хуваарилах, ашиглах асуудлыг хоёр талт олон улсын хэлэлцээр, төсөл хэрэгжүүлэх гэрээгээр зохицуулахаар заажээ.

iii. Барилга, газар тариалан, зам тээврийн салбарт үзүүлэх нөлөө

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор бусад хуульд нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд эдгээрээс онцлон дурдвал:

Барилгын салбар	Газар тариалан, зам тээврийн салбар	Тариалангийн газрын зориулалтын өөрчлөлт
Барилга байгууламж, үйл ажиллагаанаас ялгарч болох хүлэмжийн хийн хэмжээг төрийн байгууллагаас тогтооно.	Газар тариалан, зам, тээврийн салбарт хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи, инноваци, үйлдвэрлэлийн арга нэвтрүүлэхэд төрөөс дэмжинэ.	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр тариалан эрхлэхэд тохиромжгүй болсон газрын зориулалтыг холбогдох шинжилгээнд үндэслэн өөрчлөхөөр зохицуулсан.



Бидэнтэй холбогдоорой

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль, түүний хэрэгжилт болон бусад холбогдох хууль эрх зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу. Дээрх хуулийг бүрэн эхээр нь харахыг хүсвэл [энд](#) дарж танилцана уу.